



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/М2

Есенбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Чиглэл болгох тухай" 62 дугаар тогтоол, "Аймгийн 2026 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлын 2026 оны 03 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хөрөнгө оруулалт ба Түншлэлийн чуулган 2026" арга хэмжээг зохион байгуулах зардал 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийг батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

2."Хөрөнгө оруулалт ба Түншлэлийн чуулган 2026" арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

